



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**БАРИВЧЛАХ
АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ЭХ/00/2023/03/10

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.02.06

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	3
УДИРТГАЛ.....	4
ҮНДСЭН ХЭСЭГ	5
1. Америкийн Нэгдсэн Улс	5
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	6
3. Бүгд Найрамдах Солонгос Улс	8
4. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	9
5. Испанийн Хант Улс.....	12
6. Канад Улс.....	14
7. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	15
ДҮГНЭЛТ	18
ЭХ СУРВАЛЖ	20

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ИХУ	Испанийн Хант Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

УДИРТГАЛ

Судалгааны зорилго:

Тус судалгааны зорилго нь гадаадын зарим улс орны хууль тогтоомжид сэжигтнийг баривчлах үндэслэлийг тусгасан байдал, баривчлах эрх бүхий албан тушаалтан, сэжигтнийг баривчилснаас хойш шүүхэд шилжүүлэх хугацаа, түүнийг шийдвэрлэх процесс болон шүүхийн ажиллах хуваарийг харьцуулан судлахад оршино.

Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү судалгаанд АНУ, БНХАУ, БНЛУ, ИБУИНХУ, ХБНГУ, ИХУ, Канад улсын Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хууль, Цагдаагийн байгууллагын хууль болон бусад процессын хууль тогтоомжийн хүрээнд судлав.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичигт шинжилгээ хийх, харьцуулалтын аргуудыг ашиглав.

Судалгааны бүтэц:

Тус судалгаа нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт хэсгээс бүрдэнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Үндсэн хуульд орсон “дөрөвдүгээр” нэмэлт, өөрчлөлтөөр “... хүнийг баривчлах зөвшөөрлийг шүүгч юм уу магистрат (англ.*magistrate*) олгох бөгөөд ийнхүү зөвшөөрөл олгохдоо үндэслэл бүхий нөхцөл байдал (магадлал бүхий шалтгаан) бий болсон байх” шалгуурыг тавьсан. Тус нэмэлт өөрчлөлтийн агуулга нь ерөнхий, өргөн хүрээтэй тул тодорхой тохиолдолд шүүхээс хууль тайлбарлах эрхийн хүрээнд казуаль тайлбар гаргах замаар сэжигтнийг баривчлахтай холбоотой хууль хэрэглээний жишгийг тогтоож ирсэн байна.

АНУ-ын Холбооны болон муж улсуудын хуульд хүнийг баривчилсны дараа шүүхийн өмнө үндэслэлээ тайлбарлах хугацааг “даруй”, “шаардлагагүйгээр хугацаа алдалгүй” гэх зэргээр хуульчилсан байдаг.¹ Тухайлбал, Холбооны Улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 4 дүгээр зүйлд гомдлын дагуу дуудан ирүүлэх, баривчлах тухай зохицуулсан бөгөөд 4-ийн (b)-ийн 1-ийн (C)-д баривчлагдсан этгээдийг шаардлагагүйгээр хугацаа алдалгүй магистрат шүүгчийн өмнө авчрахыг, ийм бодит боломжгүй бол тухайн мужийн юм уу орон нутгийн шүүхийн ажилтны өмнө авчрахыг тушаах гэж заажээ.²

Эдгээр “даруй”, “шаардлагагүйгээр хугацаа алдалгүй” гэх цаг хугацааны тодорхой хэмжээсгүй нэр томъёог АНУ-ын дээд шүүхээс 1991 онд *County of Riverside v. McLaughlin* нарын хэргийг шийдэхдээ 48 цаг гэж тайлбарласан. Үүнд ажлын цагаар хязгаарлагдахгүй буюу амралтын өдрүүд болон аливаа баяр ёслолын өдрүүд нь орж тоологдох юм. Уг хугацааг тодорхойлохдоо шүүх бүрэлдэхүүн 5:4-ийн харьцаатай олонхын саналаар шийдсэн байдаг. Эсрэг саналтай 4 шүүгчийн 3 нь энэ хугацаа нь 36 цаг байх нь зохимжтой хэмээн үзсэн бол Antonin Scalia шүүгч 24 цаг байх ёстой гэсэн санал гаргаж байжээ. Олонхын саналыг төлөөлж Sandra Day O'Connor шүүгч саналаа тайлбарлахдаа хуулийн хэрэгжилтийн бодит байдал болон хувь хүний эрх хоорондын практик шинжтэй тэнцвэрийг хангах зорилгод 48 цаг нийцэх тул цаашид даруй, шаардлагагүй хугацаа алдалгүй гэх нэр томъёог энэ хугацаагаар тооцох нь зүйтэй гэжээ.³ Хэрэв 24 цаг гэж тогтоовол орон даяар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх механизмыг хурдасгах шаардлагатай болох ба нэмэлт хууль сахиулагч болон магистратын нэмэлт орон тоо бий болгох шаардлага үүсэж төсөвт дарамт болох талаар мөн дурджээ.⁴

АНУ-д Холбооны болон муж улсуудын эрүүгийн процессын хуульд баривчлах санал, хүсэлтийг шүүх ямар хугацаанд шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй. Баривчлах зөвшөөрөлтэй эсхүл зөвшөөрөлгүй эсэхээс үл хамааран заавал шүүхийн өмнө 48 цагийн дотор баривчлагдсан этгээдийг авчрах ёстой. Шүүхээс баривчлах зөвшөөрөл

¹ David.W.Neubauer, *America's Courts and Criminal Justice System*, 2019, p.286

² [Rule 4. Arrest Warrant or Summons on a Complaint | Federal Rules of Criminal Procedure | LII / Legal Information Institute \(cornell.edu\)](#) (Сүүлд үзсэн: 2023.01.16).

³ David.W.Neubauer, *America's Courts and Criminal Justice System*, 2019, p.289

⁴ Мөн тэнд.

олгосон тохиолдолд зөвшөөрөлтэй баривчлагдсан этгээдийг шүүхийн өмнө даруй авчрах нь дараах ач холбогдолтой байдаг.⁵

- Баривчлагдсан этгээд гомдолд дурдсан этгээд мөн болохыг баталгаажуулах;
- Баривчлагдсан этгээдэд холбогдсон хэргийн талаар мэдээлэл өгснөөр тэрээр хамгаалах байр сууринаас хуралдаанд бэлтгэж эхлэх;
- Баривчлагдсан этгээдэд өмгөөлөгч авах, дуугүй байх, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг эсхүл тангарагтны шүүхээр орох зэрэг эрхүүдийг нь тайлбарлаж өгөх;
- Баривчлагдсан этгээдийг шоронд үлдээх буюу огоорч, мартагдах эсхүл тэдэнд туслах боломжтой хүмүүсээс тусгаарлахаас хамгаалах;
- Хууль сахиулагчдыг баривчлагдсан хүнтэй нууцаар болон уртасгасан байцаалт авахаас сэргийлэх;
- Баривчлагдсан хүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн үр дүнг хүлээх хугацаанд батлан даалтаар суллагдах боломжийг эрт олгох;
- Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх талаар шийдвэрээ шуурхай гаргах боломжийг олгох;
- Баривчлагдсаны дараа үргэлжлүүлэн хорих буюу цагдан хорих нөхцөл байдал бий эсэх талаар шүүхийн шийдвэрийг даруй хүлээн авах зэрэг болно.

Харин баривчлах зөвшөөрөлгүйгээр хүнийг баривчилсан бол ийнхүү баривчлах “магадлал бүхий шалтгаан” бий эсэхийг шүүхээс шалгадаг. Магадлал бүхий шалтгаан гэдгийг нарийвчлан тодорхойлсон хууль байхгүй боловч АНУ-ын дээд шүүхээс 1964 онд шийдсэн *Beck v. Ohio* гэх хэрэгт “баривчлах үед хэргийн үйл баримт, нөхцөл байдлын талаар хууль сахиулагчийн олж мэдсэн зүйл нь сэжигтнийг гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл үйлдсэн гэж итгэл төрүүлэхүйц буюу түүнийг баривчлах зөвшөөрөл олгоход хангалттай хэмжээний үндэслэл бүхий, найдвартай мэдээлэл байна” хэмээн тодорхойлсон.⁶

Сэжигтнийг баривчилснаас хойш дээр дурдсан хугацаанд түүнийг шүүхийн өмнө авч ирэхийг “*arraignment*” буюу анхны сонсгол (англ.*initial hearing*) явуулах ажиллагаа хэмээн нэрлэдэг. Жишээ болгож Нью Йорк мужийн шүүхийн ажиллах цагийн хуваарийг судалж үзвэл тус мужийн Бронкс дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд баривчлагдсан этгээдэд холбогдох хэргийн анхны сонсгол явуулах боломжтой цагийн хуваарийг даваа-ням гаригийн өглөөний 09 цагаас шөнийн 01 цаг хүртэл хэмээн тогтоожээ.⁷ Үүнээс үзэхэд тус шүүхэд баривчлах зөвшөөрөл олгох, холбогдох хэргийг шүүхэд сонсгох гэх мэт сэжигтнийг баривчилсны дараах ажиллагааг шөнийн 01 цаг хүртэл явуулж болно гэж дүгнэж болохоор байна.

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятад улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 3 дугаар зүйлд “эрүүгийн хэрэгт мөрдөн байцаах, баривчлах...”ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэж хариуцна.

⁵ Мөн тэнд, р.286.

⁶ Cook, Joseph P. (1971), “*Probable Cause to Arrest*”, *Vanderbilt Law Review*, 24: 317-39, quoting *Beck v. Ohio*, 379 U.S. 89, 91 (1964).

⁷ Цахим эх сурвалж: <https://ww2.nycourts.gov/COURTS/nyc/criminal/generalinfo.shtml> (Сүүлд үзсэн: 2023.02.01).

Ардын прокурорын газар хяналт тавих, хорих зөвшөөрөл олгох, төрийн өмнөөс яллах, прокурорын байгууллагын шууд авч хэлэлцэх хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй. Харин шүүн таслахыг Ардын шүүх хариуцахаар хуульчилжээ.⁸

Тус улсад урьдчилан баривчлах ажиллагааг прокурор эсхүл шүүхийн зөвшөөрөлгүйгээр цагдаагийн байгууллага гүйцэтгэх боломжтой ажиллагаанд ордог. Тухайлбал, гэмт хэргийн сэжигтэн оршин суугаа газарт хяналт тогтоосон арга хэмжээг эсхүл батлан даалтын хугацаанд холбогдох журмыг зөрчсөн нь хорих шаардлагатай бол урьдчилан баривчилж болохоор тусгажээ.⁹

Цагдаагийн байгууллага ноцтой сэжигтнийг дараах үндэслэлийн аль нэг байвал урьдчилан баривчилна. (1)гэмт хэрэгт бэлтгэж байгаа, гэмт хэрэг үйлдэж байгаа эсхүл гэмт хэрэг үйлдсэн дор нь илрүүлсэн; (2)хохирогч эсхүл болсон явдлыг нүдээр харсан хүн гэмт хэрэгтнийг таньсан; (3)бие эсхүл орон байрнаас гэмт хэргийн нотлох баримт илэрсэн; (4)гэмт хэрэг үйлдсэний дараа амиа егүүтгэх эсхүл зугтахаар завдсан; (5)нотлох баримтыг устгах, хуурамчаар үйлдэх эсхүл гэрчид нөлөөлөх болон хуйвалдаж болзошгүй; (6)овог нэр, оршин суугаа хаяг, хувийн байдлаа үнэн мэдүүлээгүй; (7)хот, муж дамжиж гэмт хэрэг үйлдсэн, урьд гурваас дээш удаа гэмт хэрэг үйлдэж байсан, хамтран гэмт хэрэг үйлдсэн ноцтой сэжигтэн гэх мэт.

Цагдаагийн байгууллагын ажилтан урьдчилан баривчлах зөвшөөрөл авах хүсэлтийг бөглөж, тус мужийн хэмжээнээс дээш түвшний цагдаагийн байгууллагын хариуцах ажилтнаас баривчлах захирамжийг авна.¹⁰ Ийнхүү цагдаагийн байгууллага баривчилсан этгээдийг 24 цагийн дотор хорих байранд хүргэж, баривчилснаас хойш 24 цагийн дотор мэдүүлэг авах бөгөөд баривчлах үндэслэл тогтоогдохгүй бол суллах гэрчилгээ өгч даруй суллана. Хэрэв баривчилсан этгээдийг хорих үндэслэл тогтоогдвол 3 өдрийн дотор Ардын прокурорын газарт хүсэлтээ гаргах ёстой. Онцгой нөхцөл байдалтай тохиолдолд хүсэлт гаргах өдрийг 1-3 өдрөөр сунгаж болно. Дээрх хорих зөвшөөрөл авахаар илгээсэн цагдаагийн байгууллагын хүсэлтийг Ардын прокурорын газар 7 өдрийн дотор зөвшөөрөл өгөх эсхүл зөвшөөрөл өгөхгүй эсэх талаарх хариуг шийдвэрлэх ёстой.¹¹

Хэрэв Ардын прокурорын газраас хорих зөвшөөрөл өгөөгүй бол баривчилсан этгээдийг даруй суллана. Харин хорих үндэслэлгүй буюу гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай нотлох баримт байхгүй боловч үргэлжлүүлэн мөрдөн байцаах ажиллагаа явуулах шаардлагатай бол хуульд заасны дагуу батлан даалт гаргуулах, оршин суугаа газарт хяналт тогтоох арга хэмжээ авна. Хэрэв цагдаагийн газраас прокурорын шийдвэрийг эс

⁸ БНХАУ-ын Эрүүгийн хууль, <https://www.pkulaw.com/chl/5a06769be1274052bdfb.html?keyword=%E5%88%91%E4%BA%8B%E8%AF%89%E8%AE%BC%E6%B3%95&way=listView> (Сүүлд үзсэн:2023.01.30).

⁹ Мөн тэнд, 71, 77 дугаар зүйл.

¹⁰ Цагдаагийн байгууллагын эрүүгийн хэргийг гүйцэтгэх журмын 125 дугаар зүйл, <https://www.pkulaw.com/chl/bef0133425642a74bdfb.html?keyword=%E5%85%AC%E5%AE%89%E6%9C%BA%E5%85%B3%E5%8A%9E%E7%90%86%E5%88%91%E4%BA%8B%E6%A1%88%E4%BB%6%E7%A8%8B%E5%BA%8F%E8%A7%84%E5%AE%9A&way=listView> (Сүүлд үзсэн:2023.01.30).

¹¹ БНХАУ-ын Эрүүгийн хууль, <https://www.pkulaw.com/chl/5a06769be1274052bdfb.html?keyword=%E5%88%91%E4%BA%8B%E8%AF%89%E8%AE%BC%E6%B3%95&way=listView> (Сүүлд үзсэн:2023.01.30).

зөвшөөрвөл баривчилсан этгээдийг даруй суллаж, дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй.

Прокурорын байгууллагын шууд авч хэлэлцэх хэргийг мөрдөн шалгах явцад гэмт хэрэг үйлдсэний дараа амиа егүүтгэх эсхүл зугтахаар завдсан эсхүл нотлох баримтыг устгах, хуурамчаар үйлдэх эсхүл гэрчид нөлөөлөх болон хуйвалдаж болзошгүй баривчлах үндэслэл тогтоогдвол Ардын прокурорын газрын шийдвэрээр цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ. Ийнхүү баривчилсан этгээдээс 24 цагийн дотор мэдүүлэг авах бөгөөд баривчлах үндэслэл тогтоогдохгүй бол суллах гэрчилгээ өгч даруй суллана. Харин баривчилсан этгээдийг хорих шаардлагатай гэж үзвэл 14 хоногийн дотор шийдвэрээ гаргах ёстой байдаг.¹²

3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгос улсын Эрүүгийн процессын хуулийн 200-2, 200-3 дугаар зүйлд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах болон яаралтай баривчлах хоёр нөхцөлийг хуульчилжээ.¹³

Шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах ажиллагааны талаар авч үзэхэд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл байгаа этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол прокурор эрүүгийн хэргийн сэжигтнийг харьяа дүүргийн шүүхийн шүүгч, цагдаагийн ахлах офицер хүсэлтээ прокуророор дамжуулан тухайн дүүргийн шүүхийн шүүгчийн гаргасан баривчлах захирамжаар баривчлан саатуулж болно. Прокурор, шүүхийн цагдаагийн ажилтны хүсэлтэд дээд тал нь 500,000 воноос дээшгүй хэмжээний торгууль ногдуулах хэрэг, хөнгөн гэмт хэрэг, бага хэмжээний торгуулиар оногдох хэрэгт тухайн сэжигтэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүсэлтээс татгалзсан болон оршин суух хаяггүй бол баривчилна.

Дүүргийн шүүгч дээрх хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл баривчлах зөвшөөрөл олгох бөгөөд хүсэлтийг хүлээн авсан дүүргийн шүүгч баривчлах захирамж гаргаагүй тохиолдолд хүсэлтийн агуулга, үндэслэлийг дурдаж гарын үсэг зурж, битүүмжилж, хүсэлт гаргасан прокурорт буцаана. Сэжигтнийг хуульд заасны дагуу баривчлан хорьсон тохиолдолд 48 цагийн дотор хүсэлт гаргаагүй бол сэжигтнийг чөлөөлнө.

Яаралтай баривчлах ажиллагааны талаар авч үзэхэд тухайн этгээдийг цаазаар авах, тодорхойгүй хугацаагаар ажил хийлгэх хорих бол гурван жилээс доошгүй хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэх үндэслэлтэй бөгөөд хугацаа алдахгүйн улмаас тухайн дүүргийн шүүгчийн баривчлах захирамжийг авах боломжгүй бол прокурор, шүүхийн цагдаагийн ахлах ажилтан үндэслэл шалтгаанаа тодорхой дурдан сэжигтнийг баривчилж болно.¹⁴ Сэжигтэн:

- Нотлох баримтыг устгах магадлалтай;

¹² Мөн тэнд.

¹³ Criminal Procedure Act. Act №17572. 2020.12.08. 200/2-200/3 дугаар зүйл. <https://www.law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2&query=CRIMINAL%20PROCEDURE%20ACT#iBgc/orO> (Сүүлд үзсэн: 2023.02.02).

¹⁴ Мөн тэнд.

- Зугтаах магадлалтай бол яаралтай баривчилна.

Цагдаагийн ахлах офицер гэмт хэргийн сэжигтнийг баривчлах тохиолдолд нэн даруй прокуророос зөвшөөрөл авна. Яаралтай баривчлах тохиолдолд хэргийн гол агуулга, яаралтай баривчлах үндэслэл, ач холбогдолтой мэдээллийг мэдүүлэгт тусгаж прокурор, цагдаагийн ахлах ажилтан мэдүүлгийг нэн даруй бэлтгэнэ.

Прокурор, цагдаагийн ахлах ажилтан гэмт хэрэгтнийг баривчилсан тохиолдолд прокурор хугацаа алдалгүйгээр дүүргийн шүүхийн шүүгчид, цагдаагийн ахлах ажилтан прокурорт хүсэлт гаргах ба прокурор дүүргийн шүүхийн шүүгчид хорих зөвшөөрөл олгох хүсэлтийг гаргана. Хорих зөвшөөрөл олгох хүсэлтийг, мэдүүлгийн хамтаар сэжигтнийг баривчилсан үеэс эхлэн 48 цагийн дотор гаргана эсхүл хүсэлтээ гаргаагүй тохиолдолд сэжигтнийг нэн даруй суллана. Суллагдсан этгээдийг дахин ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр баривчилж болохгүй.

Прокурор сэжигтнийг дээр дурдсанаар хорих хүсэлт гаргахгүйгээр сулласан тохиолдолд 30 өдрийн дотор шүүхэд мэдэгдэнэ. Яаралтай баривчилсан мэдүүлгийн хуулбар болон дараах зүйлүүдийг хавсаргана:

- Яаралтай тохиолдол болон суллагдсан этгээдийн хувийн мэдээлэл;
- Яаралтай баривчилгааны цаг хугацаа болон орон зайн зайлшгүй тодорхой үндэслэл;
- Цаг хугацаа орон зайн улмаас сулласан шалтгаан;
- Гэмт хэргийн сэжигтнийг яаралтай баривчилсан болон сулласан прокурор болон цагдаагийн ахлах офицерын нэр.

Цагдаагийн ахлах офицер хорих зөвшөөрөл олгох хүсэлт гаргахгүйгээр яаралтай тохиолдлоор баривчилсан гэмт хэргийн сэжигтнийг сулласан бол прокурорт нэн даруй мэдээлнэ. Шүүгч баривчлах хүсэлт болон яаралтай баривчлах хүсэлтийг хүлээн аваад хугацаа алдалгүйгээр шийдэх бөгөөд өөр онцгой тохиолдол үгүй бол хорих хүсэлт хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр шийдвэрлэнэ.¹⁵

4. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

ИБУИНХУ-д сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүйгээр баривчлах үндэслэлийг ялгаатай тогтоосон байна. Цагдаа ба Эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай хууль (англ. *Police and Criminal Evidence Act, 1984*)-ийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дараах тохиолдлуудад *шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах ажиллагаа* явуулж болно. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж буй хүн;
- Гэмт хэрэг үйлдэж байгаад баригдсан хүн;
- Гэмт хэрэг үйлдэх гэж буй талаарх үндэслэл бүхий сэжиг байгаа бол;
- Гэмт хэрэг үйлдэж байгаа талаарх үндэслэл бүхий сэжиг байгаа бол тухайн этгээдийг цагдаагийн ажилтан шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилж болохоор хуульчилжээ.

¹⁵ Мөн тэнд.

Мөн хуулийг дагаж мөрдөх журмын G хэсгийн¹⁶ 1.4 дэх заалтад дээрх үндэслэлүүд нь бүх төрлийн гэмт хэргүүдэд хамаарна хэмээн тогтоосон бөгөөд дараах хоёр элемент хангагдсан нөхцөлд баривчлах ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан гэж үздэг байна. Үүнд:

1. Баривчилж буй этгээд нь гэмт хэрэг үйлдэхэд оролцсон, завдсан, эсхүл оролцсон талаарх үндэслэл бүхий сэжиг таамаг байгаа;
2. Тухайн этгээдийг баривчлах ажиллагаа явуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэх үндэслэл бүхий итгэл үнэмшил байгаа бол.

Тус улсад сэжигтнийг баривчлахад “*necessity*” буюу зайлшгүй шаардлагатай байх зарчим үйлчилдэг. Цагдаагийн албан хаагч гэмт хэргийн шинж, хохирогчийн байдал, сэжигтний нөхцөл байдал, цаашид мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгцээ зэргийг хэрэг тус бүрд харгалзан үзэж, дүн шинжилгээ хийх замаар зайлшгүй шаардлагатай байдлыг тодорхойлно.¹⁷ Зайлшгүй байдлыг тодорхойлох дараах шалгууруудаас нэг эсхүл хэд хэдэн шалгуур хангагдсан бол баривчлах ажиллагаа хууль ёсны шаардлага хангасан гэж үзнэ. Үүнд:¹⁸

- Гэмт этгээд өөрийн нэрийг хэлэхээс татгалзсан, эсхүл жинхэнэ нэрээ нуусан гэж үзэх үндэслэлтэй нөхцөлд түүний нэрийг тогтоох зорилгоор;
- Гэмт этгээд өөрийн гэрийн хаягийг өгөхөөс татгалзсан, эсхүл худал хаяг өгсөн гэж үзэх үндэслэлтэй нөхцөлд түүний гэрийн хаягийг тогтоох зорилгоор;
- Өөрийн болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулах; бусдыг гэмт хэрэгт өдөөн хатгах буюу өөрийн эрүүл мэндэд халдах эрсдэл үүсгэх; бусдын эд хөрөнгөд хохирол учруулах; нийтийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг үйлдэх; хууль бусаар хурдны зам хаах зэрэг хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох, сэргийлэх зорилгоор;
- Хүүхэд болон бусад нийгмийн эмзэг гишүүдийг хамгаалах зорилгоор;
- Гэмт хэрэг, эсхүл баривчилж буй этгээдийн үйлдлийг хурдан шуурхай, үр дүнтэй шалган тогтоох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах зорилгоор;
- Гэмт этгээдийг оргон зугтахаас сэргийлэх зорилгоор гэх мэт.

Цагдаа ба эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “нотлох баримтыг хамгаалах, хадгалах, олж тогтоох зорилгоор” баривчлагдсан сэжигтнийг цагдаагийн байгууллагад түр саатуулж /*detention*/ болно. Түр саатуулах үндэслэлийг сэжигтнийг цагдаагийн байгууллагад хүргэгдэж ирснээс хойш боломжит хугацааны /*as soon as practicable*/ дотор бичгээр үйлдэнэ. Сэжигтнийг 24 цагийн хугацаанд түр саатуулж болох ба дараах үндэслэлүүдээс аль нэг нь тогтоогдсон бол тус

¹⁶ ИБУИНХУ-д “Цагдаа ба Эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай” хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх нарийвчилсан журмууд бүхий А-Н хүртэлх 6 цуврал кодууд батлагдсан байдаг. Эдгээр зааварчилгаа кодуудын зорилго нь цагдаагийн байгууллагын эрх хэмжээ болон ард иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах тэнцвэрийг хангахад чиглэнэ. Баривчлах ажиллагаатай холбоотой нарийвчилсан журмуудыг “G” хэсэгт /кодод/ заасан байна. <https://www.gov.uk/guidance/police-and-criminal-evidence-act-1984-pace-codes-of-practice> (Сүүлд үзсэн: 2023.01.30).

¹⁷ Police and Criminal Evidence Act Code G /Code of Practice for the statutory power of arrest by Police officers/, 2012, section 2.8, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/903814/pace-code-g-2012.pdf (Сүүлд үзсэн: 2023.01.31)

¹⁸ Мөн тэнд, 2.9.

хугацааг дуусахаас өмнө мөрдөн шалгах байгууллагын даргын¹⁹ зөвшөөрлөөр 36 цаг хүртэлх хугацаагаар сунгаж болно. Үүнд:²⁰

1. Нотлох баримтыг хамгаалах, хадгалах, олж тогтоох; Сэжигтэнд холбогдуулан шалгаж буй хэрэг нь хүнд гэмт хэрэг бөгөөд,
2. Хэрэгт идэвхтэй болоод шуурхай мөрдлөг явуулж байгаа бол түр саатуулах хугацааг сунгаж болно.

Баривчлагдсан сэжигтнийг саатуулах ажиллагаа хууль ёсны шаардлагад нийцсэн эсэх, түр саатуулах хугацааг сунгах шаардлагатай эсэхэд тодорхой хугацааны давтамжтайгаар хяналт тавина. Тодруулбал, сэжигтнийг түр саатуулах шийдвэр гарснаас хойш 6 цагийн дотор эхний хяналтыг хэрэгжүүлэх ба үүнээс хойш 9 цаг тутамд хяналт тавих ажиллагааг тусгай чиг үүрэг бүхий цагдаагийн албан хаагч явуулна.²¹ Сэжигтнийг саатуулснаас хойш 24 цаг өнгөрсөн, эсхүл 2 дахь хяналтыг хугацаа өнгөрөхөөс өмнө түр саатуулах хугацааг сунгахыг хориглоно.²² Түр саатуулах хугацааг сунгахын өмнө саатуулагдсан сэжигтэн болон түүний өмгөөлөгчид мэдэгдэж амаар болон бичгээр мэдүүлэг, тайлбар гаргах боломжоор хангах шаардлагатай.²³

Дээр дурдсан үндэслэл арилаагүй буюу түр саатуулах хугацааг дахин сунгах шаардлагатай нөхцөлд сэжигтнийг баривчилсан цагдаагийн албан хаагчийн хүсэлтэд үндэслэн магистратын шүүхийн зөвшөөрлөөр 36 цагаар сунгаж болно. Энэ хугацааг дуусахаас өмнө дахин нэг удаа магистратын шүүхийн зөвшөөрлөөр 36 хүртэлх цагаар сунгах боломжтой²⁴ ба түр саатуулах нийт хугацаа 96 цагаас илүүгүй байна. Хугацааг сунгах шүүхийн хэлэлцүүлэгт саатуулагдаж буй сэжигтэн өөрийн төлөөллийг оролцуулах эрхтэй бөгөөд энэ эрхийг хангах хүртэл шүүхийн хэлэлцүүлгийг түр завсарлуулна.²⁵ Ийнхүү хугацаа сунгуулах хүсэлтийг шүүхэд өглөөний 10 цагаас оройн 21 цаг хүртэл гаргаж өгнө.²⁶

Баривчлагдсан, түр саатуулагдсан этгээдийг ямар ч үед хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах эрхээ эдлэх боломжийг хангана. Түр саатуулагдсан хүн ямар ч үед биечлэн, бичгээр болон утсаар хууль зүйн туслалцаа үзүүлэгчтэй (англ. *solicitor*) ярилцах, зөвлөлдөх, үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө авах эрхтэй.²⁷ Цагдаа болон эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт түр саатуулах ажиллагааг сунгах талаарх шийдвэр гаргахын өмнө тус ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий цагдаа сэжигтэн сэрүүн тохиолдолд сэжигтнээс, эсхүл тухайн үед боломжтой байгаа, сэжигтнийг төлөөлөх

¹⁹ Англ. police officer of the rank of superintendent or above.

²⁰ Police and Criminal Evidence Act of United Kingdom, 1984, section 42.1, <https://www.legislation.gov.uk/ukpga/1984/60/section/42> (Сүүлд үзсэн: 2023.01.31).

²¹ Мөн тэнд, 40.3.

²² Мөн тэнд, 42.4.

²³ Мөн тэнд, 42.6, 42.7.

²⁴ Мөн тэнд, 43, 44.

²⁵ Мөн тэнд, 43.3.

²⁶ Police and Criminal Evidence Act Code G /Revised code of Practice for the detention, treatment and questioning of persons by police officers/, 2014, section 15D цахим холбоос: https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/364707/PaceCodeC2014.pdf (Сүүлд үзсэн: 2023.01.31).

²⁷ Мөн тэнд, 6.1.

хууль зүйн туслалцаа үзүүлэгчээс түр саатуулах ажиллагааны талаар амаар болон бичгээр хүсэлт, тайлбар гаргах боломжоор хангана хэмээн заажээ.

Шүүхийн зөвшөөрлөөр баривчлах ажиллагааны тухайд Магистратын шүүхийн тухай хууль (англ.*Magistrates' Court Act, 1980*)-ийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар а) хүнд гэмт хэрэг, эсхүл хуульд хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдсон этгээдийг; б) 18 насанд хүрсэн хүнийг мэдээлэл авах зорилгоор шүүхэд дуудан ирүүлэх хуудсаар дуудан ирүүлэхэд гэмт этгээдийн хаяг тодорхойгүй бол шүүхийн өмнө ирүүлэхээр баривчлах зөвшөөрөл олгож болно.²⁸

Нэгтгэн дүгнэвэл, тус улсад шүүхийн зөвшөөрлөөр сэжигтнийг баривчлах тохиолдолд зөвхөн хүнд гэмт хэрэгт холбогдсон бөгөөд 18 насанд хүрсэн хүний хаяг тодорхойгүйн улмаас шүүхэд дуудан ирүүлэх боломжгүй этгээдийг шүүхийн өмнө авч ирэх зорилгоор баривчлах ажиллагаа явуулахад хамаарна. Харин аливаа этгээдийг гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа хуульд заасан “*necessity*” буюу зайлшгүй шаардлагатай байх зарчмын үндэслэлүүдийг хангасан бол шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, цаашид цагдаагийн байгууллагад түр саатуулж болно. Баривчлагдсан сэжигтнийг түр саатуулах үндсэн хугацаа 24 цаг бөгөөд цаашид сунгах эхний хугацааг мөрдөн шалгах байгууллагын дарга, хоёр болон гурав дахь хугацааг магистратын шүүхэд хүсэлт гаргах замаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Ийнхүү сэжигтнийг түр саатуулах нийт хугацаа 96 цагаас илүүгүй байна. Энэ хугацаанд 6 болон 9 цагийн давтамжтайгаар түр саатуулах ажиллагаанд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий цагдаагийн албан хаагч хяналт тавьж ажилладаг. Тус хяналтын ач холбогдол нь сэжигтнийг саатуулах ажиллагаа хууль ёсны шаардлагад нийцсэн эсэх, хугацааг цаашид сунгах шаардлагатай эсэхийг тогтооход оршино. Сэжигтнийг саатуулах ажиллагааны аль ч үед, түр саатуулах хугацааг сунгахын өмнө сэжигтэнд хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах эрхийг хангах бөгөөд сэжигтэн болон түүнд хууль зүйн туслалцаа үзүүлж буй мэргэшсэн этгээдээс (англ.*solicitor*) тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг өдрийн аль ч цагт хэрэгжүүлж болно. Түр саатуулах хугацаа сунгах, хяналт тавих ажиллагаа явуулах үед сэжигтэн сэрүүн биш бол тухайн үед оролцох боломжтой байгаа хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэшсэн этгээдийг оролцуулж тайлбар, мэдүүлэг гаргуулж болно. Шүүхэд хугацаа сунгах хүсэлт гаргах цаг хугацааны тухайд зөвхөн өглөөний 10 цагаас оройн 21 цагийн хооронд гаргах боломжтой буюу шөнийн цагаар шүүх хүсэлт хүлээн авч шийдвэрлэхгүй.

5. Испанийн Хант Улс

1978 онд батлагдсан Испани улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн (Эрх ба Эрх чөлөө), нэгдүгээр хэсгийн (Үндсэн эрх ба Нийтийн эрх чөлөө), 17 дугаар зүйлд (Хувь хүний эрх чөлөө) заасны дагуу:

- Хүн бүр эрх чөлөө, аюулгүй байдлаа хангуулах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу мөн хуульд заасан тохиолдол болон журмаас бусад тохиолдолд хэний ч эрх чөлөөг хязгаарлаж болохгүй.

²⁸ Magistrates' Court Act of United Kingdom, 1980, section 1.4. [Magistrates' Courts Act 1980 \(legislation.gov.uk\)](https://www.legislation.gov.uk) (Сүүлд үзсэн: 2023.01.31).

- Урьдчилан хорих хугацаа нь баримтыг тогтооход шаардлагатай мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахад шаардагдах хугацаанаас илүүгүй байх ёстой. Ямар ч тохиолдолд баривчлагдсан хүнийг дээд тал нь 72 цагийн дотор суллах эсхүл шүүхийн байгууллагад хүлээлгэн өгөх ёстой.
- Баривчлагдсан аливаа хүнд нэн даруй баривчилсан үндэслэлийг түүнд ойлгомжтой байдлаар мэдэгдэх ёстой бөгөөд мэдүүлэг өгөхийг албадах ёсгүй. Баривчлагдсан хүнд цагдаа, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан нөхцөлийн дагуу өмгөөлөгчийн туслалцаагаар хангах баталгаа өгнө.
- Хууль бусаар баривчлагдсан аливаа этгээдийг шүүхийн байгууллагад нэн даруй шилжүүлэн өгөхийн тулд *хабеас корпусын* (англ. *habeas corpus*)²⁹ журмыг хуулиар зохицуулна. Мөн түүнчлэн түр хугацаагаар хорих ялын дээд хугацааг хуулиар тогтоохоор хуульчилсан байна.³⁰

Тус улсын 2016 онд шинэчлэн баталсан Эрүүгийн процессын хуулийн хоёрдугаар дэвтэрт (Хураангуй ажиллагаа), дөрөвдүгээр гарчиг (Дуудах, баривчлах, түр саатуулах), хоёрдугаар бүлгийн 490 дүгээр зүйлд зааснаар аливаа этгээдийг доорх тохиолдлуудад хэн ч баривчилж болохоор тусгажээ. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэхээр зэхэж буй этгээд;
- Гэмт хэргийг үйлдэж буй этгээд;
- Ял эдэлж байгаа хорих ангиас оргож буй этгээд;
- Хорих анги болон эцсийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг эдлэх ёстой газар луу шилжүүлэхээр хүлээгдэж байхдаа оргож буй этгээд;
- Өмнөх зүйлд дурдсан байгууллага, газар руу аваачиж өгөх үед зугтсан этгээд;
- Хэрэг үүсэхээр хүлээж байх хугацаанд баривчлагдахаас зугтаж буй этгээд;
- Ялаа эдлээгүй яллагдагч болон ялтан этгээд.

Харин эрх бүхий байгууллага болон шүүхийн цагдаагийн ажилтан дараах этгээдийг баривчлах үүрэгтэй:

- Дээр дурдсан зүйлийн аль нэгд хамаарах этгээд;
- Хуульд заасны дагуу хорих ялаас илүү өндөр ялтай гэмт хэрэгт холбогдож байгаа хүн;
- Хөнгөн ялтай гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээдийн гарал үүсэл, үйлдсэн нөхцөл байдал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас дуудсан тохиолдолд ирэхгүй гэж үзсэн этгээд;
- Өмнөх зүйлд холбогдох этгээд хэдийгээр яллагдаагүй боловч (1)эрх бүхий байгууллага болон төлөөлөгч нь гэмт хэргийн шинжтэй үйл явдал оршиж буйд итгэх хангалттай үндэслэлтэй байх; (3)тэдний баривчлах гэж буй этгээд энэхүү хэрэгт оролцсон гэж үзэх хангалттай үндэслэлтэй тохиолдолд баривчлахыг үүрэг болгожээ.

²⁹ Хууль бусаар мөн тодорхойгүй хугацаагаар баривчлагдсан этгээдийг шүүхийн өмнө заргалдах эрхийг олгох зарчмын Латин нэр томъёо.

³⁰ Agencia Estatal Boletín Oficial del Estado. (2014). *THE SPANISH CONSTITUTION*. Catálogo de Publicaciones de la Administración General del Estado, Madrid, Spain. <https://www.boe.es/legislacion/documentos/ConstitucionINGLES.pdf>.

Ийнхүү дээрх үндэслэлүүдээр хувь хүн, эрх бүхий байгууллага, шүүхийн цагдаагийн байгууллагын ажилтан тухайн этгээдийг баривчилсны дараа 24 цагийн дотор түүнийг суллах эсхүл баривчлах ажиллагаа явуулсан газарт хамгийн ойр байрлах шүүхэд хүлээлгэн өгөх үүрэгтэй. Хэрэв хүлээлгэн өгөх хугацаа 24 цагаас хэтрэн хойшилсон тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Харин тухайн хэргийг шүүгч болон шүүхэд шилжүүлэн өгөх нь зөв байсан; баривчлах ажиллагааг 490 дүгээр зүйлийн 1, 2, 6, 7-д заасны дагуу явуулсан; мөн 492 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх заалтад хамрагдсан тохиолдолд тус баривчлагдсан этгээдийг хүлээлгэн өгснөөс хойш 72 цагийн дотор баривчлах ялыг үргэлжлүүлэн хорих эсхүл хүчингүй болгоно.³¹

6. Канад Улс

1985 онд батлагдсан Канад улсын Эрүүгийн хуулийн 494 дүгээр зүйл, 495 дугаар зүйлд гэмт этгээдийг шүүхийн зөвшөөрлөөр цагдаагийн байгууллагын ажилтан баривчлах болон дээрх зөвшөөрөлгүйгээр гэмт этгээдийг дурын иргэн баривчлах үндэслэлийг хуульчилжээ. Тухайлбал, хэрэв тухайн этгээдийг шүүхээр яллах боломжтой гэмт хэрэг үйлдэж байх үед; тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж; гэмт хэрэг үйлдээд зугтах болон баривчлах эрх бүхий хуулийн байгууллагын ажилтан гэмт этгээдийг хөөж байгаа тохиолдолд шүүхийн захирамжгүйгээр иргэн баривчлах эрхтэй байна. Мөн түүнчлэн байрны эзэн, хууль ёсны эзэмшигч эсхүл эрх олгогдсон этгээд тухайн байранд болон байртай холбоотой гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийг шүүгчийн захирамжгүйгээр баривчилж болохоор хуульчилжээ. Тухайлбал, тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед эсхүл тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнээс хойш үндэслэлтэй хугацааны дотор баривчилсан бөгөөд цагдаагийн байгууллагын ажилтан тухайн нөхцөл байдалд тус этгээдийг баривчлах боломжгүй байсан үндэслэлтэйгээр итгэсэн тохиолдолд баривчилсан үйлдлийг хүлээн зөвшөөрдөг байна. Хэрэв иргэн дээрх хуулиар зөвшөөрсөн буюу шүүхийн захирамжгүйгээр гэмт этгээдийг баривчилсан тохиолдолд цагдаагийн байгууллагын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгөхөөр хуульчилжээ.³²

Шүүхийн захирамжгүйгээр цагдаагийн байгууллагын ажилтан баривчлах үндэслэлийг мөн хуулиар зохицуулсан бөгөөд шүүхээр яллах боломжтой гэмт хэргийг үйлдсэн этгээд эсхүл гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үндэслэлтэйгээр итгэсэн болон гэмт хэрэг үйлдэж байх үед нь барьсан тохиолдлыг хуульчилсан байна.³³ Харин дараах тохиолдлуудад цагдаагийн байгууллагын ажилтан заавал шүүхийн захирамж авахаар тусгасан байна. Үүнд:

- 553 дугаар зүйлд³⁴ заасан шүүхээр яллах боломжтой хэргүүд;

³¹ Ministerio de Justicia. (2016). *CRIMINAL PROCEDURE ACT*. Subdirección General de Documentación y Publicaciones, Madrid, Spain. <https://www.mjusticia.gob.es/es/AreaTematica/DocumentacionPublicaciones/Documents/Criminal%20Procedure%20Act%202016.pdf>.

³² Minister of Justice. (2023). *Criminal Code R.S.C., 1985, c. C-46*. Canada. <https://laws-lois.justice.gc.ca/PDF/C-46.pdf>.

³³ Мөн тэнд.

³⁴ Эл үндэслэлд заавал нотлох баримт шаардах бөгөөд тухайлбал, хулгайн хэрэгтэй холбоотой мэдээлэл, залилангаар мөнгө болон эд хөрөнгө эзэмших, энэ төрлийн гэмт хэргийн дагалдан болох,

- Хүнд болон хүндэвтэр гэмт хэрэгт холбогдох этгээд;
- Хөнгөн гэмт хэрэгт холбогдох этгээд;
- Олон нийтийн ашиг сонирхлын үүднээс: (тухайн этгээдийн нэр, хаягийг тодорхойлох), (хэргийн баримт нотолгоог хадгалах ба хамгаалах), (тухайн гэмт хэрэг үргэлжлэх, ахин давтагдах болон бусад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх) гэх мэт тухайн этгээдийг баривчлахгүйгээр хангагдаж болох тохиолдолд;
- Тухайн этгээдийг баривчлахгүй бол шүүхэд дуудагдсан мэдэгдлийн дагуу шүүхэд ирэхгүй гэж үзэх ямар ч үндэслэлгүй тохиолдол хамаарна.

Хэрэв шүүх байгууллага тухайн этгээд цагдаагийн байгууллагын ажилтнаар баривчлагдсанаас хойш 24 цагийн дотор хэвийн үйл ажиллагаа явуулж байвал элдэв үндэслэлгүйгээр холбогдох шатны шүүхэд шилжүүлэх түүнчлэн, хэрэв шүүх байгууллага тухайн этгээд цагдаагийн байгууллагын ажилтнаар баривчлагдсанаас хойш 24 цагийн дотор хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй бол тус этгээдийг шүүх байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой болмогц холбогдох шатны шүүхэд нэн даруй шилжүүлэхээр хуульчилжээ.³⁵

7. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын Эрүүгийн процесс ажиллагааны хуульд “түр баривчлах” болон “урьдчилан хорих” гэсэн ойлголтууд байдаг. Шүүгчийн захирамжийн үндсэн дээр хүнийг баривчлах үндэслэлийг уг хуулийн §§115, 115а-д заасан бол шүүгчийн захирамжгүйгээр прокурор, цагдаа хүнийг түр баривчлах тухай уг хуулийн §§127, 127б, 128-д тус тус заасан байна. Шүүгчийн захирамжгүйгээр хүнийг түр баривчлах эрхийг 1) “Хүн бүр”-д олгосон баривчлах эрх болон 2) Прокурор, цагдаагийн албан хаагч хүнийг түр баривчлах эрх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ гэж үздэг.

“Хүн бүр”-д олгосон баривчлах эрх */jedermann/, §127 Abs. 1 StPO* нь Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §127.1-т гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдсан эсвэл түүнээс хойш нэн даруй тухайн хүнийг оргон зайлж болзошгүй эсвэл хувийн байдал нь шууд тогтоогдохгүй гэх үндэслэлээр баривчлах эрхийг “хүн бүрд” олгосон байна. Уг зохицуулалтад тусгасан “хүн бүр” гэх ухагдахуунд прокурор болон цагдаагийн албан хаагчийг хамруулан ойлгох эсэх нь маргаантай байдаг. Учир нь уг хуулийн §127.1-т “тухайн хүний хувийн байдлыг шууд тогтоох боломжгүй бол прокурор болон цагдаагийн албан хаагч энэ хуулийн §163 б-д заасан арга хэмжээг авна” хэмээн заасан байдагтай холбоотой. Гэхдээ дийлэнх судлаачид “хүн бүр” гэх ойлголтод прокурор болон цагдаагийн албан хаагч хамаарна гэж үздэг бөгөөд хүний хувийн байдлыг тогтоох зорилго агуулаагүй бол прокурор, цагдаагийн албан хаагч эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §127.1-т заасан үндэслэлээр хүнийг түр хугацаагаар баривчилж болно гэж хэмээн үздэг байна. Үүнээс дүгнэвэл Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §127.1 нь гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдсан эсвэл түүнээс хойш нэн даруй гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүнийг “хувь хүн”

хууль бус мөрийтэй тоглоомыг явуулах байр орон сууцаар хангах, худал мэдүүлэг өгөх, мөн шүүхийн бусад шийдвэрүүдийг зөрчих гэх зэрэг орно.

³⁵ Minister of Justice. (2023). *Criminal Code R.S.C., 1985, c. C-46*. Canada. <https://laws-lois.justice.gc.ca/PDF/C-46.pdf>.

баривчлах эрхтэй бол цагдаагийн албан хаагч тухайн гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүн оргон зайлж болзошгүй гэх үндэслэлээр түр баривчлах эрхийг олгосон зохицуулалт байна.

Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §127.1-т заасан түр баривчлах эрх хэдий хугацаанд үргэлжлэх талаар авч үзвэл: Хувь хүн дээрх үндэслэлээр хүнийг түр хугацаагаар саатуулсан бол цагдаагийн албан хаагч иртэл эсвэл цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгснөөр баривчлах эрх дуусгавар болно. Харин прокурор болон цагдаагийн албан хаагч дээрх үндэслэлээр хүнийг түр баривчилсан бол хорих үндэслэлийг шалгаж дуусах хүртэлх хугацаанд баривчлах эрхтэй байх бөгөөд хүнийг түр баривчилснаас хойш дараагийн өдөр хүртэлх хугацааг ойлгодог байна.

Прокурор болон цагдаагийн албан хаагчийн хэрэгжүүлэх баривчлах эрх (§ 127 Abs. 2 StPO) нь прокурор, цагдаагийн албан хаагч хойшлуулшгүй тохиолдолд болон хорих захирамж, цагдан хорих тушаал гаргах урьдчилсан нөхцөл бүрдсэн бол хүнийг түр хугацаагаар шүүгчийн захирамжгүйгээр түр баривчилж болох тухай эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §127.2-т заасан байна.

Хорих захирамж, цагдан хорих захирамж гаргах нөхцөл бүрдсэн байх хэмээх ойлголт нь сэжигтнийг гэмт хэрэг үйлдсэн байх магадлалтай гэх ноцтой сэжиг байгаа болон хорих үндэслэл байгаа тохиолдолд сэжигтний эсрэг урьдчилан хорих арга хэмжээ авна. Ноцтой сэжиг гэдэгт гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүн гэмт хэргийн гүйцэтгэгч эсвэл хамтран оролцогч байж болох өндөр магадлал бүхий илэрхий нөхцөл байдал үүссэнийг ойлгоно.

Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §112.2-т дараах нөхцөлүүдийг хорих захирамж гаргах үндэслэл байна гэж заажээ. Үүнд: Сэжигтэн оргон зайлсан эсвэл нуугдаж байгаа нь тодорхой баримтаар тогтоогдсон, тухайн хэргийн нөхцөл байдлыг үнэлэхэд сэжигтэн мөрдөн байцаалтаас зугтах эрсдэлтэй, сэжигтэн дараах үйлдлийг хийнэ гэсэн илэрхий хардалтыг бий болгосон бол нотлох баримт устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, эсвэл хуурамч нотлох баримт бий болгох, гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон хэмээн сэжиглэж байгаа хүн, гэрч, хэргийн баримтыг хуурах аргаар нөлөөлөх, эсвэл бусад иймэрхүү үйлдэл хийх мөн мөрдөн шалгах ажиллагааны бодит байдалд хүндрэл учруулах эрсдэл бий бол, гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэл байгаа §112а, онц ноцтой гэмт хэрэгт сэжиглэж байгаа тохиолдол хамаарна.

Цагдаагийн албан хаагч хүнийг түр хугацаагаар баривчилсан тохиолдолд нэн даруй шүүхэд шилжүүлнэ. Энэ нь Холбооны Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд хүн бүр шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхтэй, 104 дүгээр зүйлд хүнийг халдашгүй байх эрхийг хязгаарлахыг шүүхийн шийдвэрт үндэслээгүй бол нэн даруй шүүхийн шийдвэр гаргана” хэмээн заасантай холбоотой. Цагдаагийн албан хаагч хүний эрх чөлөөг хязгаарлан түр хугацаагаар баривчилсан тохиолдолд §128.1-т зааснаар “нэн даруй, баривчилснаас хойш нэг өдрийн дотор” /хамгийн ихдээ 48 цаг/ тухайн хүнийг шүүхэд шилжүүлэх ёстой. Нэн даруй, баривчилснаас хойш нэг өдрийн дотор шүүхэд шилжүүлэх хугацааг календарийн хугацаагаар тоолно. Хэрэв хуульд заасан хугацаанд хүнийг шүүхэд шилжүүлээгүй бол эрх чөлөөг нь хязгаарлах ажиллагаа дуусгавар болж тухайн хүнийг суллана.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн §13.2-т шүүхийн шийдвэрээр орон байранд нэгжлэг хийх тухай, мөн §104.2-т хүний эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ нь шүүхийн шийдвэрт

үндэслээгүй бол нэн даруй шүүхийн шийдвэр гаргана хэмээн заасантай холбогдуулан Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангахын тулд жижүүр шүүгчийг ажиллуулдаг байна. Жижүүр шүүгчийн ажиллах нөхцөлийг хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн тусгасныг авч үзвэл:

1975 онд баталсан Шүүх байгуулах тухай хуульд 1994 оны нэмэлт, өөрчлөлтөөр шүүхэд жижүүр шүүгч ажиллуулах тухай анх тусгажээ. Уг хуулийн §22с.1-т Муж улсын засгийн газраас гаргаж буй хэм хэмжээний актад өөрөөр заагаагүй бол орон нутгийн шүүх жижүүр шүүгч ажиллуулж болно хэмээн заасан. Германд муж улсууд өөрийн шүүхийн тогтолцоо, хэрэг хянан шийдвэрлэх журмыг тогтоохдоо шүүхийн төвлөрлийг сааруулах зарчмыг удирдлага болгодог бөгөөд жижүүр шүүгчийг ажиллуулах хуваарилалт муж болгонд өөр өөр байна. Тухайлбал: Нийдерзаксен мужид Верденийн орон нутгийн шүүх жижүүр шүүгчийн үүргийг бүхэлд нь гүйцэтгэдэг байхад зарим мужуудад хэдэн хэдэн орон нутгийн шүүхүүд хамтран жижүүр шүүгчийн хуваарийг гаргадаг байна. Ихэнх шүүхэд жирэмсний амралттай байгаа шүүгчийг жижүүр шүүгч хийх үүргээс чөлөөлдөг. Мөн зарим шүүхэд эрүүл мэндийн шалтгаанаар шүүгч хүсэлтээ өгвөл жижүүр шүүгчийн үүргээс чөлөөлөгдөж болдог байна. Жижүүр шүүгчид тусгай албаны утас хүлээлгэн өгдөг бөгөөд цагдаагийн албан хаагчид тухайн өдөр хуваарилагдан ажиллаж буй жижүүр шүүгчийн утасны дугаарыг өгдөг.

Цагдаагийн албан хаагч сэжигтнийг түр баривчлах үед ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх, баривчилснаас хойш дараагийн өдөр дуусахаас өмнө шүүхэд шилжүүлэх, мөн өмгөөлөгчтэй холбогдох, өмгөөлөгчтэй хамт байцаалт өгөх зэрэг эрхүүдийг сануулдаг бөгөөд хэрэв сэжигтэн өмгөөлөгчөө сонгох боломжгүй бол түүнд үүргийн өмгөөлөгчийг санал болгоно. ХБНГУ-д үүргийн өмгөөлөгч хэмээх ойлголт байдаг бөгөөд энэхүү өмгөөлөгчийг шүүхээс томилдог байна. Эрүүгийн процесс ажиллагааны хуульд үүргийн өмгөөлөгчийг *notwendiger verteidiger* гэж нэрлэдэг бөгөөд уг хуулийн §140.1-д өмгөөлөгч заавал оролцуулах тохиолдлуудыг нэрлэжээ. Өмгөөлөгч заавал оролцуулах тохиолдолд Эрүүгийн процесс ажиллагааны хуулийн §§ 112, 112 а-д зааснаар сэжигтнийг урьдчилан хорих эсвэл §126 а эсвэл §275 а дугаар зүйлийн 6-д зааснаар түр хугацаагаар цагдан хорих бол өмгөөлөгчийг заавал оролцуулахаар заасан байна.

ДУГНЭЛТ

Энэхүү харьцуулсан судалгааны хүрээнд нэгтгэн дүгнэхэд, Америк, Их Британи, Солонгос, Канад, Испани, Герман зэрэг улсад баривчлах ажиллагааны зөвшөөрлийг шүүгчийн захирамжаар олгодог бол Хятад улсад цагдаа, прокурор бие даан явуулах ажиллагаанд хамаарч байна. Хятад, Испани улсаас бусад улсад шүүхийн зөвшөөрөлтэй болон шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэлийг тусад нь хуульчилжээ. Тухайлбал, **шүүхийн зөвшөөрөлгүй** буюу зайлшгүй шаардлага (хойшлуулшгүй тохиолдол)-ын улмаас баривчлах үндэслэлийг АНУ-д магадлал бүхий шалтгаан бий эсэх буюу сэжигтнийг гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл үйлдсэн гэж итгэл төрүүлэхүйц буюу түүнийг баривчлах зөвшөөрөл олгоход хангалттай хэмжээний үндэслэл, бүхий найдвартай мэдээлэлтэй байхаар тодорхойлсон бол Солонгос улсад цаазаар авах, гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэх үндэслэлтэй бөгөөд нотлох баримтыг устгах, зугтаах магадлалтай тохиолдолд, Их Британид гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж буй хүн, гэмт хэрэг үйлдэж байгаад баригдсан хүн, гэмт хэрэг үйлдэх гэж байгаа, эсхүл үйлдэж байгаа талаарх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд, Герман улсад сэжигтнийг гэмт хэрэг үйлдсэн байх магадлалтай гэх ноцтой сэжиг байгаа болон хорих үндэслэл байгаа тохиолдолд, Канад улсад шүүхээр яллах боломжтой гэмт хэргийг үйлдсэн этгээд эсхүл гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үндэслэлтэйгээр итгэсэн болон гэмт хэрэг үйлдэж байх үед нь барьсан гэх мэт ялгаатай зохицуулсан байна.

Харин Герман, Канад, Испани зэрэг улсад шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах эрхийг прокурор, цагдаагийн байгууллагаас гадна хүн бүрд олгожээ. Өөрөөр хэлбэл, дээрх улсын хууль тогтоомжид сэжигтэн гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдсан, оргон зайлж болзошгүй эсхүл хувийн байдал шууд тогтоогдохгүй гэх нийтлэг үндэслэл болон хуульд заасан нөхцөл байдал бий бол хүн бүр баривчлах эрхтэй. Канад улсын онцлог зохицуулалтаас дурдахад байрны эзэн, хууль ёсны эзэмшигч мөн тэдгээрээс эрх олгогдсон этгээд орон байранд болон байртай холбогдолтой гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлахаар хуульчилсан байдаг. Гэвч энэхүү хүн бүрд олгосон эрх нь шүүх, цагдаагийн байгууллагын ажилтан ирэх эсхүл хүлээлгэн өгөх хүртэл, прокурор цагдаагийн байгууллагын ажилтны хувьд шүүхэд хүлээлгэн өгөх хүртэл үргэлжилнэ.

Прокурор, цагдаагийн ажилтан гагцхүү **шүүхийн зөвшөөрөлтэй** баривчлах ажиллагаа явуулах үндэслэлийг Канад улсад хөнгөн, хүнд, хүндэвтэр гэмт хэрэг холбогдох этгээдийг баривчлах тохиолдолд, Их Британид хүнд гэмт хэрэг эсхүл хуульд хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдсон этгээдийг түүнчлэн, 18 насанд хүрсэн хүнийг мэдээлэл авах зорилгоор шүүхэд дуудан ирүүлэх хуудсаар дуудан ирүүлэхэд гэмт этгээдийн хаяг тодорхойгүй тохиолдолд, Солонгос улсад гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл бүхий этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд, АНУ-д үндэслэл бүхий нөхцөл байдал болсон байх гэх зэргээр тусгажээ. Харин Хятад, Испани улсад хуульд заасан үндэслэл бий бол цагдаагийн ажилтан баривчлах үүрэгтэй байхаар хуульчилжээ.

Ийнхүү хуулиар олгосон баривчлах эрх, үүргийн хүрээнд шүүхийн зөвшөөрөлгүй эсхүл шүүхийн зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран аливаа этгээдийг баривчилсан хэн ч бай заавал шүүхийн өмнө үндэслэлээ тайлбарлах буюу шүүхэд хүлээлгэн өгөх хугацааг Америк,

Солонгос, Герман зэрэг улсад 48 цаг, Их Британи, Испани, Канад зэрэг улсад 24 цаг байхаар тогтоожээ. Тухайлбал, Их Британид сэжигтнийг 24 цаг түр саатуулж болох бөгөөд хуульд заасан үндэслэл тогтоогдсон тохиолдолд мөрдөн шалгах байгууллагын даргын зөвшөөрлөөр 36 цаг, дахин сунгах шаардлагатай нөхцөлд магистрат шүүгчийн зөвшөөрлөөр 36 цаг сунгаж болохоор хуульчилсан байна. Испани улсад 24 цагийн дотор шүүхэд хүлээлгэн өгөх эсхүл суллах үүрэгтэй бөгөөд тус улсын Үндсэн хуульд баривчлах нийт хугацааг 72 цаг байхаар тусгажээ.

Баривчилсан, түр хоригдсон сэжигтний өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилтийг АНУ-д баривчлагдсан этгээдийг нэн даруй магистрат шүүгчийн өмнө авчрахыг, ийм бодит боломжгүй бол тухайн мужийн эсхүл орон нутгийн шүүхийн ажилтны өмнө авчрах нь баривчлагдсан этгээдэд холбогдсон хэргийн талаар мэдээлэл өгснөөр тэрээр хамгаалах байр сууринаас хуралдаанд бэлтгэж эхлэх түүнчлэн, баривчлагдсан этгээдэд өмгөөлөгч авах, дуугүй байх, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг эсхүл тангарагтны шүүхээр орох зэрэг эрхүүдийг нь тайлбарлаж өгөх зэрэг ач холбогдолтой байдаг бол Их Британид сэжигтнийг саатуулах ажиллагааны аль ч үед, түр саатуулах хугацааг сунгахын өмнө сэжигтэнд хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах эрхийг хангах бөгөөд сэжигтэн болон түүнд хууль зүйн туслалцаа үзүүлж буй мэргэшсэн этгээдээс */solicitor/* тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг өдрийн аль ч цагт хэрэгжүүлж болно. Түр саатуулах хугацаа сунгах, хяналт тавих ажиллагаа явуулах үед сэжигтэн сэрүүн биш бол тухайн үед оролцох боломжтой байгаа хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэшсэн этгээдийг оролцуулж тайлбар, мэдүүлэг гаргуулах, Испанид баривчлагдсан аливаа хүнд нэн даруй баривчилсан үндэслэлийг түүнд ойлгомжтой байдлаар мэдэгдэх ёстой бөгөөд мэдүүлэг өгөхийг албадах ёсгүй. Баривчлагдсан хүнд цагдаа, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан нөхцөлийн дагуу өмгөөлөгчийн туслалцаагаар хангах баталгаа өгнө, Герман улсад цагдаагийн албан хаагч сэжигтнийг түр баривчлах үед ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх, баривчилснаас хойш дараагийн өдөр дуусахаас өмнө шүүхэд шилжүүлэх, мөн өмгөөлөгчтэй холбогдох, өмгөөлөгчтэй хамт байцаалт өгөх зэрэг эрхүүдийг сануулдаг бөгөөд хэрэв сэжигтэн өмгөөлөгчөө сонгох боломжгүй бол түүнд үүргийн өмгөөлөгчийг санал болгоно. Эрүүгийн процесс ажиллагааны хуульд үүргийн өмгөөлөгчийг сэжигтнийг урьдчилан хорих эсвэл түр хугацаагаар цагдан хорих бол заавал оролцуулахаар заасан байна.

Шүүхийн ажиллах цагийн хуваарийг авч үзэхэд Нью Йорк мужийн Бронкс дүүргийн эрүүгийн хэргийн шүүхэд баривчлагдсан этгээдэд холбогдох хэргийн анхны сонгол явуулах боломжтой цагийн хуваарийг өглөөний 09 цагаас даваа-ням гаригийн шөнийн 01 цаг хүртэл тогтоосон бол Их Британид өглөөний 10 цагаас 21 цаг хүртэл хугацаа сунгах хүсэлт гаргах боломжтой байна. Харин Герман улсын Нийдарсаксон мужид Верденийн орон нутгийн шүүх жижүүр шүүгчийн үүргийг бүхэлд нь гүйцэтгэдэг байхад зарим мужуудад хэдэн хэдэн орон нутгийн шүүхүүд хамтран жижүүр шүүгчийн хуваарийг гаргадаг байна. Цагдаагийн албан хаагчид тухайн өдөр хуваарилагдан ажиллаж буй жижүүр шүүгчийн тусгай утасны дугаарыг өгнө.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Minister of Justice. (2023). *Criminal Code R.S.C., 1985, c. C-46*. Canada. <https://laws-lois.justice.gc.ca/PDF/C-46.pdf>
- Ministerio de Justicia. (2016). *CRIMINAL PROCEDURE ACT*. Subdirección General de Documentación y Publicaciones, Madrid, Spain. <https://www.mjusticia.gob.es/es/AreaTematica/DocumentacionPublicaciones/Documents/Criminal%20Procedure%20Act%202016.pdf>
- Criminal Procedure Act. Act №17572. 2020. <https://www.law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2&query=CRIMINAL%20PROCEDURE%20ACT#liBqcolor0>
- Magistrates' Court Act of United Kingdom, 1980 [Magistrates' Courts Act 1980 \(legislation.gov.uk\)](https://www.legislation.gov.uk/ukpga/1980/16/section/1)
- Police and Criminal evidence Act of United Kingdom, 1984, section 42.1 цахим холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/1984/60/section/42>
- БНХАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, <https://www.pkulaw.com/>
- БНХАУ-ын Эрүүгийн процессын хууль, <https://www.pkulaw.com>
- Police and Criminal Evidence Act Code G /Code of Practice for the statutory power of arrest by Police officers/, 2012, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/903814/pace-code-g-2012.pdf

Гадаад хэлээр:

- Цагдаагийн байгууллагын эрүүгийн хэргийг гүйцэтгэх журам, <https://www.pkulaw.com>
- ИБУИНХУ-д “Цагдаа ба Эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай” хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх нарийвчилсан журмууд <https://www.gov.uk/guidance/police-and-criminal-evidence-act-1984-pace-codes-of-practice>
- [Rule 4. Arrest Warrant or Summons on a Complaint | Federal Rules of Criminal Procedure | LII / Legal Information Institute \(cornell.edu\)](https://www.law.cornell.edu/llr/vol11/issue1/11-1-10.html)
- <https://www2.nycourts.gov/COURTS/nyc/criminal/generalinfo.shtml>
- David.W.Neubauer, *America's Courts and Criminal Justice System*, 2019, p.286
- Cook, Joseph P. (1971), “Probable Cause to Arrest”, *Vanderbilt Law Review*, 24: 317-39, quoting *Beck v. Ohio*, 379 U.S. 89, 91 (1964).
- Agencia Estatal Boletín Oficial del Estado. (2014). *THE SPANISH CONSTITUTION*. Catálogo de Publicaciones de la Administración General del Estado, Madrid, Spain. <https://www.boe.es/legislacion/documentos/ConstitucionINGLES.pdf>

---o0o---